# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 13 өдөр　　　Дугаар А/427　　　Арвайхээр

## Хөрөнгө шийдвэрлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам батлах тухай” 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хужирт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 06-50 ӨВО Land Cruiser-100, Есөнзүйл сумын Сум дундын эмнэлгийн 15-28 УБП, УАЗ-469 Хантер маркийн авто машинуудыг акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдахаар хавсралтаар баталсугай.

2.Хөрөнгө данснаас хасах “Авто тээврийн үндэсний төв” болон Татварын хэлтсийн бүртгэлээс хасуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, орлогыг “Орон нутгийн өмч худалдсаны орлого” дансанд төвлөрүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн Өмчийн газар (З.Балданням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА　　　А.ИШДОРЖ

011100907

D:My Doc. Zahiramj. Zasag darga